



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/Н

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгж, иргэнд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хос хүч ХХК-ны "Хаш" зочид буудлын 13/212, Хасэбэ интернэшил ХХК-ны "Цэцэг" зочид буудлын 13/224, Пийсвинд ХХК-ны "Алтан говь" дэн буудлын 16/017, Ариг Эрдэнэ ХХК-ны "Холидей" зочид буудлын 14/117, Эхийн Лха ХХК-ны "Топаз" зочид буудлын 15/002, Ган оюу шонхор ХХК-ны "Шонхор" дэн буудлын 14/011, Иргэн Х.Мөнхжаргалын "Тэгш" дэн буудлын 15/030 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

6. 6.Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Огнисувд/-д үүрэг болгосугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 05 сарын 08
өдрийн 00 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

1117139265
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.05.08

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Улсын бүртгэлийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хос хүч ХХК	2589818	Хаш	БЗД-ийн 6-р хороо 13а байр
2	Хасэбэ интернэшнл ХХК	2076721	Цэцэг	БЗД-ийн 1-р хороо Залуучуудын өргөн чөлөө 18
3	Ариг Эрдэнэ ХХК	2543192	Холидей	БЗД-ийн 2-р хороо Б.Доржийн гудамж 20
4	Эхийн Лха ХХК	5125146	Топаз	СБД-ийн 5-р хороо Үндсэн хуулийн гудамж 29

-ооОо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 05 сарын 09 өдрийн дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.05.08

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Улсын бүртгэлийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Пийсвинд ХХК	5059089	Алтанговь	ЧД-ийн 1-р хороо 1-40000 13-2
2	Ган оюу шонхор ХХК	5274281	Шонхор	СХД-ийн 4-р хороо Их нарангийн 1-1а
3	Иргэн Х.Мөнхжаргал	ШД73103106	Тэгш	СХД-ийн 11-р хороо Хонхорын 1-13

-ооОо-